# ЗАХИРГАА, ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв /мян.төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт** | | | | | | | |
| *"Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хянал шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэ гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:* | | | | | | | |
| 3.1.1 | Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд хяналт тавих; | - | Нийтийн ил тод мэдээллийн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дугаар заалтын дагуу 48 мэдээллийг вебсайт хуусанд бүрэн, үнэн, зөв байршуулан ажлын тайланг ДАМГ-т 2024 оны 07 дугаар сарын 09, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ. | Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу 48 мэдээллийг 2023 оны байдлаар 59.5 хувьтай байршуулсан. | Байгууллагын нээлттэй мэдээллийг ил тод болгож, иргэдийн мэдээлэл хайх, хүлээж авах эрхийг хангасан байна. - | Нийгмийн даатгалын байгууллагын чиг үүрэгт хамаарах нээлттэй мэдээллийг олон нийтэд хүргэх, тэдний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор аймгийн Нийгмийн даатгалын газрын цахим хуудсанд байршуулах "Нээлттэй мэдээллийн жагсаалт", мэдээллийн самбарт байршуулах мэдээллийн жагсаалтыг хариуцан ажиллах ажилтнуудыг газрын даргын тушаалаар батлуулж ажиллав. -<br>Дээрх ажлын хүрээнд мэдээллийн самбарт байршуулах 12 мэдээллийг бүрэн байршуулав.<br>Цахим хуудсанд байршуулах 48 мэдээлэл тавигдахаас бүрэн байршуулан ажиллаа. Цаашид цахим хуудсанд байршуулах мэдээллийг бүрэн, үнэн зөв, цаг хугацаанд тогтмол байршуулан ажиллахыг холбогдох албан тушаалтанд үүрэг болгов. | 100 |
| 3.1.2 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих; | - | Нийгмийн даатгалын байгууллагын сан, үйл ажиллагаатай | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, 167 | Нийгмийн даатгалын байгууллагын санхүү болон сангийн мэдээллийг хуулийн | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тухай бүрд нь хяналт тавин ажиллаж байна.<br>Шилэн дансны мэдээллийн нэгдсэн | |

# ЗАХИРГАА, ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв /мян.төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| ***Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*** | | | | | | | |
| *“Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:* | | | | | | | |
| 3.1.1 | Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд хяналт тавих; | - | Нийтийн ил тод мэдээллийн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дугаар заалтын дагуу 48 мэдээллийг вебсайт хуусанд бүрэн, үнэн, зөв байршуулан ажлын тайланг ДАМГ-т 2024 оны 07 дугаар сарын 09, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ. | Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу 48 мэдээллийг 2023 оны байдлаар 59.5 хувьтай байршуулсан. | Байгууллагын нээлттэй мэдээллийг ил тод болгож, иргэдийн мэдээлэл хайх, хүлээж авах эрхийг хангасан байна. | Нийгмийн даатгалын байгууллагын чиг үүрэгт хамаарах нээлттэй мэдээллийг олон нийтэд хүргэх, тэдний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор аймгийн Нийгмийн даатгалын газрын цахим хуудсанд байршуулах “Нээлттэй мэдээллийн жагсаалт”, мэдээллийн самбарт байршуулах мэдээллийн жагсаалтыг хариуцан ажиллах ажилтнуудыг газрын даргын тушаалаар батлуулж ажиллав.<br>Дээрх ажлын хүрээнд мэдээллийн самбарт байршуулах 12 мэдээллийг бүрэн байршуулав.<br>Цахим хуудсанд байршуулах 48 мэдээлэл тавигдахаас бүрэн байршуулан ажиллаа. Цаашид цахим хуудсанд байршуулах мэдээллийг бүрэн, үнэн зөв, цаг хугацаанд тогтмол байршуулан ажиллахыг холбогдох албан тушаалтанд үүрэг болгов. | 100 |
| 3.1.2 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих; | - | Нийгмийн даатгалын байгууллагын сан, үйл ажиллагаатай | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, 167 | Нийгмийн даатгалын байгууллагын санхүү болон сангийн мэдээллийг хуулийн | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тухай бүрд нь хяналт тавин ажиллаж байна.<br>Шилэн дансны мэдээллийн нэгдсэн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | холбоотой мэдээллийг хагас жилийн байдлаар 85 мэдээллийг 07 дугаар сарын 09-ны өдрийн дотор, жилийн эцсийн байдлаар 167 мэдээллийг Shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулан ДАМГ-т 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ. | мэдээллийг 2023 оны байдлаар 95.7 хувьтай хугацаандаа мэдээлэл байршуулсан. | хугацаанд бүрэн байршуулж, иргэдийг үнэн, зөв мэдээллээр хангасан байна. | системд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тухай жилийн батлагдсан төсөв, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, санхүүгийн тайлан, батлагдсан орон тооны өөрчлөлт, дараа жилийн төсвийн төсөл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнд сар бүрийн үйл ажиллагааны санхүүжилтийн дүн, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээнд түлш халаалтын дүн, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн дүн, 5 дээш жил ажилласан төрийн захиргааны 22 албан хаагчдад үндсэн цалингийн 6 сартай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгосон дүн, сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, газрын даргын тушаалын дагуу тусламж дэмжлэгт олгосон мөнгөн дүнг тус тус pdf, хүснэгтэн хэлбэрээр өссөн дүнгээр сар бүр тогтмол хуулийн хугацаанд мэдээллийг байршуулан ажилласан байна. Үүнд:<br>• Тухай бүрт оруулах– 9 мэдээллийг 12 удаа<br>• Сар бүр оруулах– 4 мэдээллийг 12 удаа<br>• Хагас жилээр оруулах– 4 мэдээлэл<br>• Бүтэн жилээр оруулах–3 мэдээллийг тус тус нийт 159 мэдээлэлийг бүрэн байршуулсан байна. | 100 |
| *"Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:* | | | | | | | |
| 3.2.1 | Нийгмийн даатгалын | Шаард- | Холбогдох хууль | Илэрсэн | Шалгалтын үр дүнг | Нийгмийн даатгалын ерөнхий газрын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тухай хуулийн хэрэгжилтийг дээд газраас өгсөн чиглэлийн дагуу болон хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага болон дотоодын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах. | лагагүй | тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг шалгаж, илэрсэн төлбөр, зөрчлийн 70.0 аас доошгүй хувийг барагдуулж ажиллана. | төлбөр зөрчлийн 72,6 хувийг барагдуулж ажилласан. | тухай бүрд нь тооцон, хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна. | 2024 оны төлөвлөгөөт хяналт шалгалтаар 16 аж ахуйн нэгжээс 6 аж ахуйн нэгж үйл ажиллагаа зогссон 10 байгууллага шалгалтанд хамрагдсан. Шалгалтаар 7 байгууллага нь нийт 49,9 сая төгрөгийн өр үүсгэснийг шалгалтын хугацаанд төлүүлэв.<br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан удирдамжийн дагуу уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэж буй 9 аж ахуйн нэгжүүдэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийлээ. Шалгалтаар “Степ голд” ХХК 17.7, “Хан тамсаг” ХХК 21,4, “Пенин” ХХК 2,9, “Окс лимитэд операторс” ХХК 45,2, “Стэп ийст” ХХК 31,1, “Шинь шинь” ХХК 24,3, “Есүй бэхи” ХХК 39.8, “Ванчин цутгалт” ХХК 15,1, “Тунгуан майнз” ХХК 18,2, “Найнги” ХХК 84,8 тус тус эрсдэл үнэлэгдлээ. “Шинь шинь” ХХК нь Хөдөлмөрийн болон бусад төрлийн гэрээ байгуулаагүй ажил хөдөлмөр эрхлэдэггүй хүний нийгмийн даатгалын шимтгэлийг төлдөг зөрчилд зөрчлийн тухай хуулийн дагуу 5,0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан.<br>Дотоодын хяналт шалгалтаар 10 байгууллагад зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж 1,8 сая төгрөгний шимтгэл, алданги 0,7 сая төгрөг, 9 байгууллагад 6,3 сая төгрөгний торгуулийг тус тус тооцож бүрэн барагдуулан ажилласан. Улсын байцаагчийн актаар 9 байгууллагад шимтгэлд 5,1 сая төгрөг, алданги 0,7 сая төгрөг нийт 5,8 сая төгрөгийн зөрчил илэрүүлэн зөрчлийг бүрэн барагдуулан ажилласан. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3.2.2 | Хил хамгаалах ерөнхий газартай 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан 03/НД-22/23 дугаартай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд зохион байгуулж хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг нэгтгэж дүгнэх, | Шаард-лагагүй | Хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд зохион байгуулж хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнг хагас, бүтэн жилээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудаас гаргуулан авч нэгтгэж дүгнэх, | Хил хамгаалах ерөнхий газартай хамтран ажиллах санамж бичгийг 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр шинэчлэн байгуулсан. | Холбогдох судалгаа, тооцоо, дүгнэлтэд үндэслэн Хилийн цэргийн анги, тусгай салбартай хамтарсан шалгалт хийж үр дүнг тооцож, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж ажиллах | Хил хамгаалах ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд Монгол Улсын Хилийн тухай хууль, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухй хууль болон Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хил хамгаалах байгууллагын албан хаагч, улсын хил дээр алба хааж байгаа офицер, ахлагч нарын ажил эрхлээгүй гэр бүл, Хилийн цэргийн сургуульд сонсогчоор суралцсан болон хугацаат цэргийн алба хаасан иргэдийн хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж авах эрхийг баталгаажуулах чиглэлээр Дорнод аймагт байрлах хилийн цэргийн */0132, 0198, 0275, 0306 дугаар/* ангиудтай хамтарсан ажлын хэсэг байгуулан, 2024 онд үргэлжлүүлэн ажлын төлөвлөгөө гарган, ажлын хэсгээс холбогдох зөвлөмжийг өгч ажилласан.<br>Энэхүү ажлын хүрээнд хилийн цэргийн анги, салбаруудын санхүүгийн болон шимтгэл төлөлтийн тайлан, ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлсний сан, ажилтан, албан хаагчдын хамрагдалтыг холбогдох үндсэн баримтад тулгуулан шалгаж, илэрсэн зөрчлийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж ажиллаа.<br>Санамж бичгийн хэрэгжилтэд талууд холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгон 2 цэргийн ангид улсын байцаагчийн актаар 7 албан хаагчийн төлөгдөөгүй 0,5 сая төгрөгийн шимтгэлийг 2024 онд бүрэн нөхөн төлүүлж ажилласан хугацааг тогтоогоод байна. | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.3 | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2021-2023 оны орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шалгалт хийх | | 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд ҮОМШӨ-ний сангийн зарцуулалтад хяналт шалгалт хийж илэрсэн зөрчилд хуулийн дагуу хариуцлага тооцож, үр дүнд хяналт тавьж ажиллах, | - | ҮОМШӨ-ний сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөл болон анхан шатны баримтад тулгуурлан 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд шалгаж, илэрсэн зөрчлийн 80 хүртэл хувийг барагдуулж ажиллах | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан удирдамжийн дагуу Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2021-2023 оны бүрдүүлэлт зарцуулалтанд хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар 1 иргэний үйлдвэрлэлийн ослын тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн байхад энгийн тэтгэвэр тогтоосон зөрчлийг илрүүлэв. Тус иргэнд 666,4 мянган төгрөгийг нөхөн олгож сан хооронд шилжүүлхээр 4,7 сая төгрөгийг улсын байцаагчийн акт тогтоож ажиллалаа. | 100 |
| 3.2.4 | Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод төлөвлөгөөт шалгалт хийх | - | Хяналт шалгалт хийсэн объектын тоогоор , гүйцэтгэлийн хувь, хууль сахин мөрдөлтийн түвшин, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт, Эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь | - | Их, дунд эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл хувийг шалгаж, ирэлсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах | 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан 16 аж ахуйн нэгжээс 6 аж ахуйн нэгж үйл ажиллагаа зогссон 10 байгууллага шалгалтанд хамрагдсан. Авто агро ХХК нь шинэ ажилчдыг нийгмийн даатгалд хамруулаагүй зөрчилд 500,0 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсныг барагдуулсан байна.<br>7 байгууллага нь нийт 49,9 сая төгрөгийн өр үүсгэснийг шалгалтын хугацаанд төлүүлсэн. Онхоодой өндөр ХХК нь 50,6 хувийн эрсдэлтэй 12 сая төгрөгийн өр төлөгдөөгүй тул дансыг хааж ажилласан. Нийт байгууллагын хууль сахин мөрдөлтийн хувь 53,4 хувь, эрсдэл 57,6 буюу өмнөх шалгалтаас 5,0 хувь өссөн байна.<br>Нийт зөрчил: ажилчдын ажилласан жилийг буруу тооцосон, хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа ажилчдын код нэршлийг буруу бичсэн, дотоод хяналт шалгалт ажилладаггүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэн авч ажиллуулаагүй, цэргийн алба хаасан хугацаа болон нөхөн даатгалтай иргэдийг ажилласан жилд нэмээгүй, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ахмадын сан байгуулаагүй, өр үүссэн зэрэг зөрчил дутагдал илэрснийг газар дээр нь арилгуулж зөвлөгөө өгч ажилласан. | |
| 3.2.5 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/50 дугаар тушаалаар баталсан “Цахим хяналт, шалгалтын ажлын заавар”-ын дагуу цахим мэдээлэлд тулгуурлан хийх хяналт, шалгалтыг тогтмолжуулах, | | Нийгмийн даатгалын салбарын “Цахим хяналтын веб програм”-(http://10.9.0.5/monitoring)-д тулгуурлан хяналт, шалгалтыг сар бүр тогтмол хийж “Цахим хяналт, шалгалтын ажлын заавар”-ын 3.4-т заасан хугацаанд холбогдох газарт хүргүүлнэ. | 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд цахим хяналт, шалгалтыг тогтмолжуулж, илэрсэн зөрчлийн 80,0 доошгүй хувийг шалгаж, залруулсан. | Нийгмийн даатгалын салбарын “Цахим хяналтын веб програм”-(http://10.9.0.5/monitoring)-аас тодорхой өгөгдлийн дагуу шүүлт хийж, зөрчилтэй байх магадлалтай мэдээллийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шалгаж шийдвэрлэсэн байна. | Программ шинэчлэлт, хөгжүүлэлттэй холбогдуулан /http://10.9.0.5/monitoring/ программ ажиллахгүй байгаа тул цахим хяналт шалгалт хийгдэхгүй байгаа.<br>Шинээр нэвтрүүлсэн SICOS системд тэтгэвэр тэтгэмжийн тогтоолт, олголт, өөрчлөлт, шилжилт хөдөлгөөнийг шалгах ажлыг хийж байна. | 100 |
| 3.2.6 | Дотоодын хяналт, шалгалтын тайланг хагас бүтэн жилээр үнэн зөв гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулах, Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцож тайлан, мэдээг заасан хугацаанд хүргүүлэх, | | Дотоодын хяналт, шалгалтын хагас жилийн болон жилийн тайланг Нийгмийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн дагуу, Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг улирал тутамд | | Шалгалтын үр дүнг хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна. | Газрын дотоод хяналт шалгалтаар 2023-2024 онуудын 15121 тэтгэвэр, тэтгэмж авдаг иргэдийн тэтгэвэр, тэтгэмжийн олголт, шилжилт хөдөлгөөн, нас баралтад шалгалт хийв. Шалгалтаар дутуу олгосон тэтгэвэр авагч 42 хүнд холбогдох 7,5 сая төгрөг, илүү олгосон 65 тэтгэвэр авагчтай холбогдох 22.1 сая төгрөгийн олголтыг илрүүлэн Улсын байцаагчийн акт тогтоож бүрэн барагдуулсан. Мөн тэтгэмж илүү тогтоолгон авсан 3 иргэнд 3,5 сая төгрөгийн Улсын байцаагчийн акт тогтоож бүрэн барагдуулсан.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу аймгийн нийгмийн даатгалын газарт 2019-2023 оны байдлаар тэтгэвэр, тэтгэмжийн тогтоолт, олголтыг анхан шатны баримтад үндэслэн шалгасан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | гаргаж Хяналт, шалгалтын газарт хүргүүлнэ. | | | Шалгалтаар 5 тэтгэвэр авагчид илүү тооцон олгосон 24,7 сая төгрөгийн зөрчил тогтоогдон Улсын байцаагчын акт тавигдсан. Мөн ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орж тэтгэмж илүү авсан 2 иргэнд 3,3 сая төгрөгийн зөрчилд Улсын байцаагчийн акт тавигдсан. Уг зөрчлийн барагдуулалт 50 хувьтай байна.<br>Дотоодын хяналт, шалгалтын хагас жилийн тайланг үнэн зөв гаргаж тайлант хугацаанд хүргүүлэн ажилав. | |
| **Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.** | | | | | | | |
| *“Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:* | | | | | | | |
| 4.1.1 | Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх. | - | Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна. | 2023 оны жилийн эцсийн байдлаар аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын хэлтсүүдээс НДЕГ-аас өгсөн үүрэг даалгавар, тогтоол шийдвэр, чиглэл зөвлөмж, үйл ажиллагааны тайлан, зорилтот жилийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн авч дүгнэхэд нийт салбарын | Өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ. | Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой 82 тогтоол, тушаал шийдвэрийн биелэлтийг хагас жилээр хүргүүлж, жилийн эцсийн байдлаар дээд газраас ирүүлсэн 108 тогтоол, тушаал, шийдвэрийн биелэлтийг хугацаанд нь тайлагнасан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хэмжээнд хэрэгжилт 83,5%-тай хэрэгжсэн байна | | | |
| 4.1.2 | ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн - хугацаанд тайлагнах. | | Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд - тайлагнасан байна. | Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлт 2023 онд 89,1 %-тай хэрэгжсэн байна. | Иргэд, даатгуулагч, ААНБ-аас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, мэдээг үнэн бодит гаргаж улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ. - | Дорнод аймгийн Нийгмийн даатгалын газар нь төрөөс нийгмийн даатгалын талаар баримталж буй бодлого, нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд чанартай, хүртээмжтэй хүргэх, хууль сурталчилах, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэн ажиллаж байна<br>Тус газарт 2024 онд иргэд, даатгуулагчаас нийт 8246 өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авч шийдвэрлэсний бичгээр ирсэн 8246 өргөдөл ирсэн байна. Бичгээр ирүүлсэн өргөдлийг төрлөөр нь ангилбал:<br>-Тэтгэвэр шинээр тогтоолгосон 738<br>-Тэтгэврийн тусгай зохицуулалт 85,<br>-Тэтгэвэр өөрчлөн тогтоолгосон 329,<br>-ХЧТА тэтгэмж-2402,<br>-ЖА тэтгэмж-1232,<br>-Ажилгүйдлийн тэтгэмж-556,<br>-Нас барсан даатгуулагчийн тэтгэмж 398,<br>-Нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлүүлэх, буцаан олгуулах–286<br>-Нийгмийн даатгалын шимтгэлийн лавлагаа авах –3155<br>-Хөдөлмөрийн чадвар дахин тогтоолгох – 3<br>-Хөдөлмөрийн нөхцөл тогтоолгох -166<br>-Дотоод үйл ажиллагаатай холбоотой - 31<br><br>Дээрхи өргөдөл, гомдлыг хүлээн авч холбогдох хууль, тогтоомжийн дагуу хуулийн хугацаанд 100 хувь шийдвэрлэн ажилласан. | 100<br>- |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.3 | Нийгмийн даатгалын байгууллагын салбарын хэмжээнд архивын үйлчилгээг сайжруулах, ажил олгогч, иргэд, даатгуулагчид нийгмийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй, хөнгөн шуурхай үзүүлэх. | | Нийгмийн даатгалын хэлтэс дотооддоо болон хэлтсүүд хооронд шимтгэл төлөлтийн лавлагааг цахимаар солилцох ажлыг зохион байгуулна. | Нийгмийн даатгалын болон архивын үйлчилгээг иргэд, хуулийн этгээд, даатгуулагчдад хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үзүүлсэн. | Архивын лавлагааг цахимаар солилцох боломжийг бүрдүүлсэн байна. | Дорнод аймгийн Нийгмийн даатгалын газрын архивт байгууллагын үйл ажиллагаатай холбоотой удирдлагын байнга болон түр хадгалах, 70 жил хадгалагдах аж ахуй нэгжийн болон, даатгуулагчийн шимтгэл төлөлттэй холбоотой баримт нийт 24472 хадгалагдаж байна. Иргэдэд цаасан суурьт болон цахим мэдээллийн сангаас лавлагаа мэдээллээр үнэ төлбөргүй үйлчлэн ажиллаж байна. "Нийгмийн даатгалын байгууллагын архиваас лавлагаа олгоход баримтлах зөвлөмж"-ийн дагуу 2024 онд иргэдээс ирсэн архивын лавлагаа авах хүсэлтийг үндэслэн QR код бүхий цахим лавлагааг 1400 иргэнд олгон газар дотооддоо болон бусад аймаг, дүүргүүд хооронд шимтгэл төлөлтийн лавлагааг 120 иргэнд цахимаар солилцсон. Нийтдээ 3155 иргэнд нийгмийн даатгалын лавлагаа гарган үйлчилгээ үзүүлж ажилласан.<br>Өнгөрсөн онд хэлтэс, тасаг, сумдын байцаагчаас албан, хэрэг хөтлөлтийн явцад үүссэн буюу аж ахуйн нэгж, даатгуулагчийн шимтгэл төлөлтийн тайлан тооцоо, тэтгэвэр, тэтгэмжийн олголт болон сангийн холбогдох 267 хадгаламжийн нэгж, тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авч байгаад зогсоогдсон 539 тэтгэвэр авагчийн хувийн хэргийг бүртгэлд оруулан энэ оны I улиралд багтаан хүлээн авсан.<br>Мөн нөхөн бүрдүүлэлтээр Батлан хамгаалахын төв архиваас ирсэнийг хадгаламжийн нэгж үүсгэн архивт хүлээн авсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.4 | Батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулах. | | Төрийн албаны тухай хууль тогтоомж, журмын дагуу хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг гаргаж байна. | Хууль тогтоомжийн хүрээнд хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжоор хангах. | Орон тоо, төсвийн хүрээнд хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу гаргаж НДЕГ-т Тамгын газарт улирал бүр тайлагнасан байна. | НДЕГ-ын даргын 2024 оны 5 сарын тоот тушаалаар тус хэлтсийн орон тоог 40 ажилтантай 3 хэлтэстэй байх чиг үүргийн зохицуулалт хийгдсэн. Дээрх зохицуулалтын хүрээнд байцаагч ажилтнуудын ажил үүргийг хуваарилж холбогдох томилгоог хийн 38 орон тоотой үйл ажиллагаа явуулж байна | 100 |
| 4.1.5 | Газрын дотоод ажлыг сайжруулах чиглэлээр тодорхой, шинэлэг ажил зохион байгуулах, тайланг хүргүүлэх<br>- | | Ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолтоор заагдсан чиг үүргийг хэрэгжүүлсэн байна. | Газрын ажилтан, албан хаагчдын ажлын байрны чиг үүрэг тодорхой болсон байх.<br>- | Газрын дотоод ажлыг сайжруулсан, шинэлэг ажил үйлчилгээ нэвтрүүлсэн талаар тайланг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ. | Газрын даргын тушаалаар байгууллагын нийт ажилтнуудыг 3-4 хүний бүрэлдэхүүнтэй 5 багт хуваан "Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх-авлага бууруулах" аян зарлан ажиллаж байна.<br>Аяны хүрээнд 5.0 сая төгрөгөөс дээш нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй албан байгууллагад хяналт шалгалт хийж Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтийг шалган өрийг барагдуулах ажил зохион байгуулж байна. Багуудад сар улирал бүр ажил олгогчдын нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоог шинэчлэн гаргаж байнгын хяналттай ажиллаж байна. | 100 |
| 4.1.6 | Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацаагаар төлөвлөн боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах. | | Газрын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангасан байна. | Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр боловсруулан баталж, хэрэгжүүлнэ. | Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, үр дүнг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт тайлагнасан байна. | Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмын дагуу 24 албан хаагчдад 113,452,6 мянган төгрөгийн зэрэг дэвийн нэмэгдлийг,<br>Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/80 дугаар тушаалын дагуу 11 байцаагч нарт 73,200.6 мянган төгрөгийн мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгосон байна.<br>Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолоор "Төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох журам"-ын дагуу 13 сумын байцаагч нарт 40 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хувь, аймгийн төвийн төрийн захиргааны болон үйлчилгээний 25 албан хаагчдад 20 хувийн орон нутгийн нэмэгдэлд 154,686.4 мянган төгрөгийг олгоод байна.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/173 дугаар тушаалын дагуу 2024 оны 01 дүгээр сараас аймгийн төвийн албан хаагч, ажилчдад унаа, хоолны хөнгөлөлтийг өдрийн 10,0 мянган төгрөгөөр, сумдын байцаагч нарт өдрийн 5,0 мянган төгрөгөөр ажлын хоногт тооцож нийт 38 ажилтанд 48,232.0 мянган төгрөг, түлээ, нүүрсний хөнгөлөлт 19 ажилтанд 2,231,5 төгрөгийг тус тус олгосон байна.<br>Засгийн газрын 2024 оны “Төрийн захиргааны албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох тухай” 83 дугаар тогтоолын дагуу төрийн захиргааны албан тушаалд тасралтгүй 5 дээш ажилласан 22 албан хаагчдад үндсэн цалингийн 6 сартай тэнцэх хэмжээний 147,226.9 мянган төгрөгийг олгосон. | |
| 4.1.7 | -<br>Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх | | -<br>Авлигаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулсан байна. | Газрын ажилтнуудад авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион | Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана. | Аймгийн нийгмийн даатгалын газраас авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж төлөвлөгөөний дагуу доорх ажлыг хийж гүйцэтгэв.<br>Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контент, постер, зурагт хуудасыг байгууллагын цахим хуудас, дотоод сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээлэл сурталчилгааны самбарт байршуулан ажил олгогч, даатгуулагчдад сурталчилан ажилласан.<br>Авлигатай тэмцэх газраас авлига ашиг сонирхоос урьдчилан сэргийлэх болон соён гэгээрүүлэх чиглэлээр зохион | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байгуулах. | | байгуулж буй танхимын /2/ болон цахим /2/ сургалтад эрх бүхий албан тушаалтан болон нийт албан хаагчдыг тогтмол хамруулж байна.<br>Мөн өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан ТЗ-7 шатлалаас дээш албан хаагчдад ХАСХОМ, ХАСУМ мэдүүлэх, тайлагнах талаарх сургалтыг зохион байгуулсан байна. Тус төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажлын гүйцэтгэлийг нийгмийн даатгалын ерөнхий газарт тайлагнасан. | |
| 4.1.8 | Нийгмийн даатгалын газрын ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангаж ажиллах | - | НДЕГ-ын 2016.12.07-ны өдрийн "Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч (ажилтан)–ийн үйлчлүүлэгчтэй харилцах журам" батлах тухай А/61 дүгээр тушаал, 2019.12.13-ны өдрийн "Нийгмийн даатгалын хэлтэс (тасаг)–ийн ажлын байр, үйлчилгээний орчны стандарт" батлах тухай А/194 дугаар тушаалын хэрэгжилтийг мөрдөж ажилласан байна | - | Нийгмийн даатгалын газрын ажилтан албан хаагчдын харилцаа хандлагыг сайжруулж, ажлын байр, үйлчилгээний орчны стандарт хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Нийгмийн даатгалын газрын ажлын байр, үйлчилгээний орчны стандартын дагуу байгууллагын гадаад дотоод орчны стандарт ажлын байрны ерөнхий стандартуудыг мөрдлөг болгон ажиллаж байна. Үүнд:<br>-Төв хаалганы хаягийг "Нийгмийн даатгалын байгууллагын хаягийн нэгдсэн стандарт"-ын дагуу байршуулсан<br>-Хөгжлийн бэрхшээлтэй иргэд орох зориулалттай тусгай налуу гарцтай.<br>-Хатуу хучилттай талбай бүхий тээврийн хэрэгслийн зогсоолтой.<br>-Зориулалтын хогийн сав байршуулсан.<br>-Ногоон байгууламж байгуулсан.<br>-Мэдээллийн самбар нь ажилтнуудын мэдээллийг бүрэн байршуулсан.<br>-Ажлын байрны гэрэлтүүлгийг сайжруулан лед болон сүүн гэрэл тавьсан.<br>-Цахилгааны утас, залгуур, сүлжээний кабель утасны аюулгүй байдлыг хянаж ажиллаж байна.<br>-Цагийн бүртгэлийг "Able"-ээр | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | - | | - | | | бүртгэснээр ажлын цаг ашиглалт дээшилсэн.<br>-Үүдний хэсэгт угтах үйлчилгээний ажилтны ашиглах ширээ, сандал, компьютер,<br>- Call pro үйлчилгээний утас ажиллуулж иргэд даатгуулагчдаас санал хүсэлт хүлээн авч асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэн ажиллаж байна.<br>-Аюулгүй байдал болон үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор дуу, дүрсийг бичих боломжтой хяналтын камерыг үйлчилгээний танхим болон угтах үйлчилгээний хэсэгт байрлуулсан.<br>-Галын аюулгүй ажиллагааны заавар, журмын дагуу аюулгүй гарцны бүдүүвч зураг, газ байршуулсан,<br>-Ариун цэврийн өрөөг үйлчлүүлэгчид үнэ төлбөргүй ашиглах боломжоор хангаж нээлттэй байлгадаг,<br>-Үйлчилгээний танхим болон бусад өрөөнүүдэд үйлчлүүлэгчдийг сандлын хүрэлцээг нэмэгдүүлсэн,<br>-Хүлээлгийн танхимд 4-өөс доошгүй хүний суух сандал, угтвар ширээг байршуулсан,<br>- Сургалтын танхим болон ажилтнуудын амрах чөлөөт цагийн өрөөг тохижуулсан.<br>- Архивын хадгаламжийн нэгжийг төрөл тус бүрээр нь өнгөөр ялган хаягжуулсан,<br>- Тэтгэвэр авагчдын хувийн хэргийг тэтгэврийн төрөл, дугаараар эрэмблэн зориулалтын сейфэнд хадгалдаг.<br>Байцаагч ажилтнууд нь албан тушаалын тодорхойлтод заасан чиг | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үүргээ хэрэгжүүлэхдээ “Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч, ажилтны үйлчлүүлэгчтэй харилцах журам”-ыг баримтлан ажлын цаг ашиглалтыг сайжруулж, харилцаа хандлагадаа анхаарч ажиллаж байна. | |
| *“Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, олон нийт, харилцагч байгууллага салбар хэлтэс, тасгуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:* | | | | | | | |
| 4.2.1 - | Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах; | | Хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамруулсан хүний тоо | Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх .... удаагийн сургалтад ...... албан хаагчийг хамруулсан. | -Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх танхимын болон цахим сургалт зохион байгуулна.<br>-Шинэ ажилтныг ажлын байран дээр дадлагажуулах сургалт зохион байгуулж, хөрвөх чадвар бүхий мэргэжилтэн бэлтгэнэ. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн систем Сикос систем болон дэд системүүд дээр хэрхэн ажиллах талаар нийт байцаагч нар болон тэтгэвэр, тэтгэмж, орлого шимтгэлийн байцаагч, үйл ажиллагааны нягтлан бодогч нарт сургалт хийлээ.<br>Мөн аймгийн татварын газраас ХХОАТ-ыг цахимаар илгээх, төрийн албан хаагчдын “Монгол бичгийн мэдлэг дээшлүүлэх” сургалт, жендерийн төвөөс “Харилцан хүндэтгэе”, “Кибер аюулгүй байдлын эрх зүйн орчин”, “Нийгмийн түншлэл ба хөдөлмөрийн эрх”, Төрийн албан хаагчийн хөгжил, хамгаалал”-ын талаар нийт 55 удаагийн сургалтад давхардсан тоогоор 458 албан хаагч оролцож мэдлэг ур чадвараа дээшлүүллээ. | 100 |
| 4.2.2 | Ажил олгогч, иргэд, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, оюутан сурагчдад нийгмийн даатгалын ач | | Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион | Ажил олгогч, даатгуулагч, малчин, албан бус хөдөлмөр | Сургалт зохион байгуулж, иргэд, даатгуулагчдын нийгмийн даатгалын | ХХҮГ-аас зохион байгуулсан “Залуу малчдын зөвлөгөөн” “Тогтвортой ажлын байр” ажил олгогчдын өдөрлөг, Зүүн бүсийн ҮЭХ-ны тэргүүлэгчдийн зөвлөгөөн, ХАБЭА-н сарын аяны нээлт, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, сайн дурын даатгалын чиглэлээр сургалт зохион байгуулах; | | байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо | эрхлэгчид чиглэсэн .... удаагийн сургалтад ......... иргэд, даатгуулагчийг хамруулсан. | талаарх мэдлэг, мэдээлэл дээшилж, хамралт нэмэгдсэн байна. | Хуульчдын про боно өдөрлөг болон БОЭТ, ЗХ-ий 327 анги, ХЦ-ийн 0132-р анги, ШШГГ зэрэг 21 байгууллагад Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулга нийгмийн даатгалын цахим үйлчилгээний талаар мэдээлэл хийсэн. Сургалт мэдээлэлд нийтдээ 925 иргэд даатгуулагчид оролцсон байна.<br>Сайн дурын даатгалын төрөл хөнгөлөлт нэмэгдэхийн хэрээр нийгмийн даатгалд хамрагдах даатгуулагчдын тоо өмнөх оны мөн үеэс 8 хувиар өссөн байна. | |
| 4.2.3 | Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр өргөнөөр сурталчлах;<br>- | | Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг сурталчлах зорилгоор орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл,<br>Нийгмийн сүлжээний хуудас (фэйсбүүк)-д байршуулсан мэдээллийн тоо, хандалтын тоо.<br>Бэлтгэсэн нэвтрүүлэг, видео шторк, контент, цахим хичээл, | Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр сурталчилгаа хийсэн ....... тоо, мэдээллийн төрөл.....<br>- | Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээ болон бусад хэлбэрээр олон нийтэд ойлгомжтой, шуурхай хүргэсэн байна.<br>ХНХЯ болон НДЕГ-аас бэлтгэсэн мэдээллийг бүх албан хаагчдаар цааш түгээлгэж, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан байна. | Орон нутгийн 14 хоног тутам хэвлэгддэг "Дорнод" сонинд Нийгмийн даатгалын ач холбогдол, хуулийн шинэчилсэн найруулга, нийгмийн даатгалын цахим үйлчилгээ, үйл ажиллагааны талаар болон цаг үеийн мэдээлэл бэлдэн 22 удаагийн дугаарт хэвлүүлсэн байна<br>Оны эхнээс Нийгмийн даатгалын газрын пейж хуудсанд 72 мэдээлэл бэлтгэн байршуулсан ба ХНХЯ-наас бэлтгэсэн 84, НДЕГ-аас бэлтгэсэн 112, ЭМДЕГ-аас бэлтгэсэн 72 мэдээллийг шейрлэн иргэд даатгуулагчдад түгээн сурталчилж ажиллаж байна.<br>Нийгмийн цогц үйлчилгээний хүрээнд сумдын байцаагч нар 2187 малчинд нийгмийн даатгалын ач холбогдол, малчины сайн дурын даатгалын хөнгөлөлтийн талаар сурталчилан 400 гаруй малчины тэтгэвэр тогтоолгох баримт бичгийг үзэж, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан байна.<br>Нийгмийн даатгалын газрын пейж хуудаснаас гадна харилцагч ажил олгогчдын, сайн дурын даатгуулагчдын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | постерын тоо. Иргэд, даатгуулагчид, ажил олгогчид, зорилтот бүлгүүд буюу хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчдад чиглэсэн сурталчилгааны тоо, төрөл зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл | | | болон сум бүрийн нийгмийн даатгалын фейсбүүк хаягийг ажиллуулан харилцан мэдээлэл солилцох ажлыг эрчимжүүлэн дагагчдын тоог нэмэгдүүлж мэдээллийг түргэн шуурхай хүргэн ажиллаж байна. | |
| *"Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эрүүл мэндийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:* | | | | | | | |
| 4.3.4 | Эрүүл мэндийн магадлалын талаарх хууль тогтоомжийн талаар болон авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах | | Төрөлжсөн мэргэшлийн болон сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдэд эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль тогтоомжийн талаар болон авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр жилд 2-оос доошгүй удаа сургалт зохион байгуулсан байна. | | - | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 5 гишүүнийг Төв зөвлөлөөс 2024 оны 05 дугаар сард ZOOM-оор зохион байгуулсан авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтад хамруулав. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 448 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм", Эрүүл мэнд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/441, А/192 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар баталсан "Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалт"-ын талаарх мэдээллийг 2024 оны 01 дүгээр сард Зүүн Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрүүл мэндийн газарт Нийгмийн даатгалын газрын даргын 10, 11, 25 тоот албан бичгээр хүргүүлэв. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Түүнчлэн Зүүн БОЭТ, 3 өрхийн эрүүл мэндийн төвийн 80 гаруй эмч мэргэжилтнүүдэд эрүүл мэндийн магадлал, эмнэлгийн хуудас олгох журмын талаар мэдээлэл өгөв. | |
| *"Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:* | | | | | | | |
| 4.4.1 | Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, ажил олгогчоос ирүүлэх мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх | - | Ажил олгогчийн үндсэн мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх | Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан. | Ажил олгогчийн ЭЗҮАСА, татварын бүртгэлийн дугаарыг бүрэн бүрдүүлсэн байна. | Нийгмийн даатгалын шинэчилсэн систем нь төрийн мэдээлэл солилцооны "Хур" системтэй холбогдсон байдаг.<br>Шинээр бүртгүүлэхээр хүсэлт гаргасан аж ахуйн нэгж байгууллагын удирдлагын мэдээллийг УБЕГ-ын мэдээллийн сангаас үнэн зөв татагдаж байгаа эсэхийг хянан, бүртгэн ажиллаж байна. Ажил олгогч байгууллагын удирдлага тус байгууллагын нягтлан бодогч, хүний нөөцийн ажилтны мэдээллийг шимтгэл ногдуулалтын программд оруулж, /portal.ndaatgal.mn/-д, нэвтрэх эрх олгон ажиллаж байна. | 100 |
| | | | Ажил олгогчийн НДШ-ийн тайланд ирүүлэх даатгуулагчийн мэдээллийг бүрэн, зөв бүрдүүлсэн байх | | -Даатгуулагчийн үндсэн мэдээллийг бүрэн, зөв хүлээн авсан байна.<br>-Даатгуулагчийн төрлийг бүрэн, зөв хүлээн авсан байна.<br>-Даатгуулагчийн улсын кодыг бүрэн, зөв хүлээн авсан байна.<br>-Даатгуулагчийн ажил мэргэжлийн ангиллыг бүрэн, зөв хүлээн авсан байна. | | |
| 4.4.3 | Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, ажил олгогчоос ирүүлэх мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх | | Програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангах | | Програм хангамжуудын эрхийн тохиргоог зөв хийх, байцаагч ажилтнууд програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангаж ажилласан байна. | Газрын хэмжээнд ашиглагдаж буй программ хангамжуудын өдөр тутмын хэвийн ажиллагаанд хяналт тавьж, алдаа гарсан үед дээд шатны байгуулагатай холбогдон засаж, ажиллагааг хэвийн болгон ажилласан. Мөн энэ онд шинэ мэдээллийн нэгдсэн "core" системд/Sicos/ шилжсэнтэй холбоотойгоор бүх байцаагч, ажилтнуудад программд нэвтрэх нэр, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нууц үг, шинээр үүсгэж ажилласан. | |
| | | | МТТ-өөс хүргүүлсэн албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь ирүүлэх, бусад үүрэг болгосон ажлыг хэрэгжүүлсэн байх | | МТТ-өөс зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь үнэн зөв бүрэн ирүүлсэн байна. | МТТөвөөс зохион байгуулж байгаа судалгаа мэдээллийг цаг хугацаанд нь гаргаж нийт ажилчдад мэдээлж ажилласан бөгөөд МТТ-өөс зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд явуулж ажилласан. | 100 |

## ТАВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Үр дүнгийн үзүүлэлт | |
|---|---|---|---|
| | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт |
| 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Төрийн албаны тухай хуулинд заасан богино болон дунд хугацааны сургалт, нийгмийн даатгалын ажилтны чадавхижуулах сургалтад хамрагдах | - | НДЕГ-аас Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн систем Сикос систем болон дэд системүүд дээр хархэн ажиллах талаар нийт байцаагч нар болон тэтгэвэр, тэтгэмж, орлого шимтгэлийн байцаагч, үйл ажиллагааны нягтлан бодогч нарт сургалт хийлээ.<br>Мөн аймгийн татварын газраас ХХОАТ-ыг цахимаар илгээх, төрийн албан хаагчдын "Монгол бичгийн мэдлэг дээшлүүлэх" сургалт, жендерийн төвөөс "Харилцан хүндэтгэе", "Кибер аюулгүй байдлын эрх зүйн орчин", "Нийгмийн түншлэл ба хөдөлмөрийн эрх", Төрийн албан хаагчийн хөгжил, хамгаалал"-ын талаар нийт 27 удаагийн сургалтад давхардсан тоогоор 216 албан хаагч оролцож мэдлэг ур чадвараа дээшлүүллээ. |
| 2. | Монгол бичгийн анхан шатны мэдлэгтэй болох | Мэдлэг, ур чадвар дээшилнэ | Монгол бичгийн анхан шатны цахим сургалтанд 3 удаа хамрагдсан. |
| 3. | Нийгмийн сүлжээний хуудас (фэйсбүүк)-нд мэдээлэл оруулж сурах | | Нийгмийн даатгалын газрын пейж хуудсанд 49 мэдээлэл бэлтгэн байршуулсан ба ХНХЯ-наас бэлтгэсэн 16, НДЕГ-аас бэлтгэсэн 61, |

| | | | |
|---|---|---|---|
| | ур чадвараа дээшлүүлэх | | ЭМДЕГ-аас бэлтгэсэн 12 мэдээллийг шейрлэн иргэд даатгуулагчдад түгээн сурталчилж ажиллаж байна. |

ТАЙЛАНГ ГАРГАСАН:

ЗАХИРГАА, ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Б.ГАНХУЯГ

ХЯНАСАН:

ГАЗРЫН ДАРГА Д.АРИУНБОЛД